



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 04 өдөр

Дугаар 8/257

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн "г", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 2.1 дэхь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны ажилчдын 24-н айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулсан улсын комиссын актанд дахин хянаж үзэж тус барилгын зоорийн давхарын 6 байрыг үйчилгээний зориулалтаар өөрчлөх боломжтой эсэхэд дүгнэлт гарган шийдвэрлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Ганданповрон - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд: Б.Түмэндэмбэрэл - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Д.Төгөлдөр - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын геодези хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2. Үүссэн нөхцөл байдалд дүгнэлт гарган, 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн дотор багтаан танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Ганданповрон/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН

02 1109